



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/103

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. "Коронавируст халдвар /ковид-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотоос тус аймаг руу нэвтрэх иргэдийн ПСР шинжилгээ болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, Цэнхэрмандал сумын "Дэлүүн болдог" постны үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 31 хоногийн хугацаанд ажиллах 12 албан хаагчдын хоол, холбоо, байрны болон автомашины шатах тослох материалын зардал, аймгийн Шуурхай штабт хоногт үүрэг гүйцэтгэх жижүүрийн 5 албан хаагчдын хоолны зардлыг хавсралтаар тус тус баталсугай. .

2. Бор-Өндөр сумын "Төмөрт овоо" цэгийн хяналтын постод үүрэг гүйцэтгэх алба хаагчдын хоол, тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулсугай.

3. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 13.701.000 /арван гурван сая долоон зуун нэг мянга/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010302

Аймгийн Засаг даргын 2021 оны
02 дугаар сарын 26 өдрийн Д/103
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тээгц

Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл				Дүн
	Шатахууны зардал	Байрны зардал	Хоолны зардал	Холбоо түлш	
Цагдаагийн газар	1961000	900000	7440000	300000	10601000
Онцгой байдлын газар			3100000		3100000
Дүн	1961000	900000	10540000	300000	13701000